

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/90/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Цэгц богд төв аудит ХХК-ийн Аудитор: П.Пунцаг

Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.01.31

№

10

танай _____ -ны № _____ -т

Г

Г

ТӨГРӨГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА
Р.ЭРДЭНЭБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төгрөг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төгрөг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 4586 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох зардалд 574,319.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардалд 49,145.3 мянган төгрөгийн санхүүжилт тус тус авсан байна. Эрүүл мэндийн газар болон Эрүүл мэндийн яамнаас 322,106.7 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, аж ахуй, хангамжийн материал үнэ төлбөргүй орлого авчээ.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 4 хөтөлбөр, 42 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 32 арга хэмжээг бүрэн, 2 арга хэмжээг 30.0 хувь, 8 арга хэмжээг 70.0 хувь, нийт дүнгээр 92.0 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд сумын

070200087

Засаг даргаас 92.0 хувиар, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээгээр 90.0 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	313,424.2	281,326.4
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	497,538.2	692,100.1
Нийт хөрөнгийн дүн	810,962.4	973,426.5
Нийт өр төлбөрийн дүн		
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	810,962.4	973,426.5
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	810,962.4	973,426.5
Үйл ажиллагааны орлогын дүн	1,396,088.41	970,123.73
Үйл ажиллагааны зардлын дүн	709,176.87	807,659.62
Үйл ажиллагааны үр дүн	686,911.5	162,464.1
Үйл ажиллагааны бус үр дүн		
Үйл ажиллагааны нийт үр дүн	686,911.5	162,464.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	124,050.88	810,962.42
Тайлант оны үр дүн	686,911.53	162,464.10
Эцсийн үлдэгдэл	810,962.42	973,426.5
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	788,991.5	623,464.8
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	634,328.1	670,112.3
Үйл ажиллагааны ЦМГ	154,663.4	(46,647.5)
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(33,872.0)	(2,750.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	120,791.4	(49,397.5)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	120,791.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	120,791.4	71,393.9
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		671,469.29
Урсгал зардал		668,719.29
Хөрөнгийн зардал		2,750.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		622,071.8
Эрүүл мэндийн даатгалын сангаас		574,319.5
Орон нутгийн төсвөөс санхүүжих		47,752.0
Урьд оны үлдэгдлээс		49,397.5

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 7,862.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Бараа материалын тайланд 7,862.5 мянган төгрөгийн эм боох материалыг аж ахуй материалд бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;"

Залруулагдаагүй нийт 300.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 300.0 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрснээс, зөрчлийг арилгуулах 2 албан шаардлага, 300.0 мянган төгрөгийн зөрчилд 1 заалт зөвлөмж хүргүүлсэн.

Албан шаардлага

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин 11,047.0 мянган төгрөгийн вок 155 ширхэг, угаалгын бээлий 259 ширхэг, принтерийн хор 39 ширхэг, бичгийн цаас 164 ширхэгийг их хэмжээгээр нөөцөлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалыг их хэмжээгээр нөөцлөхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Эмийн үлдэгдэлд хугацаа дууссан 38 нэр төрлийн 6,741.3 мянган төгрөгийн эм байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-т "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх"-тэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Дотоодын хяналтыг сайжруулан хугацаа дууссан эмийг холбогдох журмын дагуу шийдвэрлэх албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Бараа материалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн эхний үлдэгдэлд 300.0 мянган төгрөгийн 50 ширхэг угаалгын бээлий байхад тайланд онд дахин 1,550.0 мянган төгрөгийн 250 ширхэг бээлий худалдан авч зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ." УСНББОУС 2, стандарттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ур чадварыг нэмэгдлийг олгохдоо улирал бүр шалгуурын дагуу дүгнэж олгох

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Төгрөг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/												
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төгрөг сумын Эрүүл мэндийн төв	2	7.8	-	-	2	7.8	2	7.8	-	-	-	-
Дүн	2	7.8	-	-	2	7.8	2	7.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Төгрөг сумын Эрүүл мэндийн төв	2	0.3	-	-	1	-	1	0.3	-	-	-	-
Дүн	2	0.3	-	-	1	-	1	0.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Төгрөг сумын Эрүүл мэндийн төв	1	11.0	-	-	1	11.0	-	-
Дүн	1	11.0	-	-	1	11.0	-	-
-Нийт дүн	3	11.3	-	-	2	11.0	1	0.3

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзса
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			